



Боловсрол, Шинжлэх Ухааны Яамны харьяа

БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

#6(15)

2023 он

VI сар

Сар тутмын хэвлэл

 <http://www.mnier.mn>

МОНГОЛ УЛСЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАРЫН “ICT EXPO - MINDGOLIA 2023” ҮЗЭСГЭЛЭНД ОРОЛЦЛОО



Монгол Улсын Мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарын хамгийн том үзэсгэлэн 2023 оны 06 дугаар сарын 9-11-ний өдрүүдэд болох “ICT EXPO – Mindgolia 2023” арга хэмжээнд оролцсон.



Тус арга хэмжээнд дараах платформ болон сайтууд танилцуулсан. Үүнд:



Боловсролын үндэсний хүрээлэнгийн сайт <https://www.mnier.mn/>, тус сайтад байрлуулсан Цахим сан, тайлан, гарын авлага, хүрээлэнгийн сонин гэх мэт цахим контентууд.



Боловсролын судалгааны монголын сэтгүүл <https://mnier.mn/journal/index.php/research> боловсрол судлалын чиглэлээр хийсэн эрдэм шинжилгээний судалгааг олон нийтийн дунд хэлэлцүүлэх, танилцуулах замаар шинэ мэдлэг бүтээх, судалгааны үр дүнг практикт хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, улмаар боловсрол судлалын шинжлэх ухааны хөгжилд хувь нэмэр оруулах цахим сайт.



“Тогтвортой хөгжлийн боловсрол” www.esd.mn веб сайт. Тогтвортой хөгжлийн боловсролын цахим талбар нь бүх нийтийг тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахад уриалсан хөтөч бөгөөд бүх түвшний оролцогч талууд хамтран суралцах, сайн туршлагыг нэвтрүүлэх, түгээхэд дэлгэрүүлэхэд хувь нэмэр оруулах нээлттэй эх сурвалж.



Математикийн сургалтыг дэмждэг “EDUTEN” платформ. Энэхүү платформ нь математикийн хичээлээ математикаас айх айдасгүйгээр тоглоомын аргаар ойлгож авах, нэг бодлогыг олон аргаар бодож, асуудал шийдвэрлэх чадварт бие даан суралцдаг, хувь хүүхдийг өөрөө суралцахуйн процессоо удирдах боломжтой болгохоос гадна багшийн хэрэглэгдэхүүн бэлдэх, анализ боловсруулах ажлын ачааллыг хөнгөлж, сурагчдын суралцах явцын тоон мэдээллийг шууд харуулдгаараа онцлогтой.



Гурван өдрийн турш бүүтэд 500 гаруй хүн зочилж мэдээлэл авсан. Математикийн сургалтыг дэмждэг “EDUTEN” платформыг нийт 223 хүн сонирхож үзсэн. Үүнээс, 86 хүүдэд, 137 том хүн үзсэн. БСҮХ-ийг сайтуудад 120 хүн QR кодоор хандалт хийсэн байна.

EDUTEN СУРГАЛТЫН ПЛАТФОРМЫН ТУРШИЛТ АМЖИЛТАЙ ӨНДӨРЛӨЖ, ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА



Туршилтын өмнөх болон туршилтын дараах үнэлгээний датаг боловсруулж, харьцуулсан шинжилгээ хийн туршилтын үр дүнгийн товч тайланг БШУЯ, мэргэжлийн байгууллагуудын удирдлагуудын хүрээнд танилцуулав. Мөн туршилтад оролцсон бүх багш нар, сургуулийн удирдлагууд, мэргэжлийн байгууллагын төлөөлөл, орчуулагчид, Финляндын Eduten-ний багийнхан хамтарсан тайлант уулзалт, батламж гардуулах ёслолыг 6-р сарын 10-ны өдөр зохион байгууллаа.



Уулзалтаар туршилт үр дүнг тоймлон танилцуулж, туршилтад оролцогчдод батламж гардууллаа. БШУ-ны сайд Л.Энх-Амгалан БСҮХ-ийн туршилт баг болон Финляндын багийнхантай уулзаж дараагийн шатанд хэрхэн хамтран ажиллах талаар ярилцав.



Туршилтад нийслэлийн 3, аймгийн 3, сумын 3, нийт 9 сургуулийн 4 дүгээр ангийн 15 бүлгийн сурагчид, багш нар, удирдлагын баг, эцэг эх асран хамгаалагчид хамрагдсан. Туршилтын өмнөх болон туршилтын дараах үнэлгээний датаг боловсруулж, харьцуулсан шинжилгээ хийн туршилтын дэлгэрэнгүй тайлан бичиж I-V ангийн агуулгыг орчуулах ажил хийгдэж байна.

Цаашид цахим шилжилтэд түүчээлэх үндэсний арга хэмжээ БШУЯ, болон Финляндын Eduten-ний багт БСҮХ-ийн зүгээс саналаа хүргүүлээд байна.

СӨБ-ЫН "АМЬДРАЛЫН МОД" СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ТУРШИХ СУДАЛГААНЫ ҮР ДҮН

“Амьдралын мод” хөтөлбөрийг туршин хэрэгжүүлэх явцад бүлгийн багш болон хүүхдэд гарч буй өөрчлөлтийг илрүүлэхдээ туршилт, хяналтын 16 цэцэрлэгийн 1680 хүүхэд, 363 багш, 678 төлөвлөлт, 232 үйл ажиллагаанд шинжилгээ хийж, 12 багшийн сургалт, үйл ажиллагааны ажиглалтын тэмдэглэл, 363 багшаас тоон болон чанарын хосолсон аргаар 1 ба 5 сард мэдээлэл цуглуулж боловсруулалт хийв. Мөн хэрэгжсэн 6 модулийн хүрээнд туршилтын 8 цэцэрлэгийн бүлгийн 90 багш нарын сургалтын чиглэл бүрээр сургалт, үйл ажиллагаанд өгсөн үнэлгээг нэгтгэн боловсруулалт хийв. Судалгааны үр дүнг БШУ-ы сайд, СӨБ-ын хэлтэс, БЕГ, БҮТ, туршилтын цэцэрлэгийн удирдлагууд, холбогдох мэргэжилтнүүдэд болон ЭЛФ хөтөлбөр ХХК-ний төлөөлөлд 2023 оны 6 дугаар сарын 20-ы өдөр танилцуулав.

Судалгаанд хамрагдсан туршилтын болон хяналтын цэцэрлэгүүдийн хүүхдийн даалгаврын гүйцэтгэл, багшийн асуулгын үр дүнд төдийлөн ялгаа харагдахгүй, зарим нэг сургалтын чиглэлийн үр дүн буурсан байв. “Амьдралын мод” хөтөлбөрийн туршилтын цэцэрлэгийн хүүхдийн даалгаврын гүйцэтгэл, багшийн сургалт, үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалтыг судалсны үр дүнд цаашид үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх боломжгүй гэж дүгнэв. Цаашид хүүхдийн хөгжлийг цогцоор дэмжих, агуулгын уялдаа холбоог хангах, үнэлгээг цахим аргаар хийх зорилгоо хангаж чадаагүй тул боловсронгуй болгох шаардлагатай байна. Мөн багшийн ажлыг хөнгөвчилж сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийг хийж өгсөн боловч зорилго, үйл ажиллагаа, үнэлгээг уялдаа холбоотой төлөвлөөгүй, нэг хэвийн, бүтээлч биш, хүүхдийн сонголт хийх боломжийг орхигдуулсан ба багш үйлийн эзэн байгаа нь өнөөгийн сургалтын үзэл санаатай зөрчилдөж байв.

БАГА БОЛОВСРОЛЫН МОНГОЛ ХЭЛНИЙ СУРГАЛТАД АШИГЛАХ УНШИХ ЭХИЙН САН БҮРДҮҮЛЭХ” ТӨСЛИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Боловсролын судалгаа үндэсний хүрээлэн “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд “Бага боловсролын Монгол хэлний сургалтад ашиглах унших эхийн сан бүрдүүлэх” төслийн ажил нь 2022 оны 8 дугаар сараас 2023 оны 6 дугаар сарын 30-ны хооронд 3 үе шаттайгаар хэрэгжүүллээ. Төслийн хүрээнд эхэд тавих шаардлага шалгуур боловсруулахад чиглэсэн баримт бичгийн судалгаа хийж, улмаар “Бага боловсролын монгол хэлний сургалтын эх сонгох, зохиох жишиг шаардлага шалгуур”-ыг боловсруулсан.

Тухайн шаардлага шалгуурт нийцсэн эхийг анги бүрээр агуулга, төрөл зүйлээр түүвэрлэн, шаардлагатай эхийг шинээр зохиолгон анги бүрд эхийн сан бүрдсэн. I-V ангийн эхийн сангаас анги бүрд тодорхой тооны эхийг бага ангийн сурагчдын хөгжлийн онцлог, хэрэгцээ сонирхолд нийцэж байгаа эсэхийн тохирцыг шинжлэх туршилтыг зохион байгуулсан.

Төслийн хүрээнд Бага боловсролын монгол хэлний сургалтын эх сонгох, зохиох жишиг шаардлага, шалгуур боловсруулж, түүнд нийцсэн 800 гаруй эхийн сан бүрдсэн байна. Эхийн санг I-V анги бүрээр, анги бүрийн эхийг уран зохиолын болон уран зохиолын бус эх, тэдгээрийн төрөл зүйлээр ангилж, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн олон нийтэд зориулсан талбарт байршуулж, сургалтад нэвтрүүлэхэд бэлэн болсон байна.

СУРГАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН БОЛОВСРУУЛАХ, ХЭВЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЦЭЭГ ТОДОРХОЙЛОХ, ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТ

Судалгаа, сургалтыг Боловсрол, шинжлэх ухааны яамны санаачилгаар Кембрижийн боловсролын түншлэл, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнтэй хамтран 2023 оны 06 дугаар сарын 05-09-ний өдрүүдэд МУБИС-ийн Математик, байгалийн ухааны сургуулийн (III) байранд зохион байгуулсан.

Олон улсын зөвлөх-сургагч багш нар сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах хэвлэхтэй холбоотой Монгол Улсын нөхцөл байдлыг тодорхойлох зорилгоор удирдлага, зохион байгуулалтын баг, хэвлэлийн ажилтан/редактор, төслийн менежер, зохиогч, редактор, дизайнер, хэвлэлийн эх бэлтгэгч, зураач зэрэг төлөөлөл оролцсон зорилтот бүлгүүдтэй фокус бүлгийн ярилцлагыг 2023 оны 06 дугаар сарын 05-06-ны өдрүүдэд хийв.

Дээрх ярилцлагын үр дүнг харгалзан сургагч багш нар 6 дугаар сарын 07-09-ний өдрүүдэд сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах, хэвлэх чиглэлээр сургалт зохион байгуулсан. Сургалтад Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Боловсролын ерөнхий газар, Боловсролын үнэлгээний төв, Боловсролын мэдээлэл, технологийн төв, Монгол Улсын их сургууль, Монгол Улсын Боловсролын их сургууль, ерөнхий боловсролын сургууль болон хэвлэлийн компанийн дизайнер, контент бүтээгч, төрийн бус байгууллагын төлөөлөл, нийт 70 орчим хүн оролцсон байна.



“ЭХ ХЭЛ ДЭЭРЭЭ БОЛОВСРОЛ ЭЗЭМШИЖ ЧАДААГҮЙ БҮХ НАСНЫ ТУВА (ЦААТАН) ҮНДЭСТЭНД ЗОРИУЛСАН ЭХ ХЭЛНИЙ СУРАЛЦАГЧИЙН ГАРЫН АВЛАГА”-ТАЙ БОЛНО

Тува хэлний гарын авлагыг тува (цаатан) хүүхдэд зориулсан тува хэл, соёлын сургалтын жишиг хөтөлбөрт үндэслэн боловсруулсан. Тус жишиг хөтөлбөр нь 2021 оны 10 сард БШУ-ны сайдын А/339 дугаар тушаалаар батлагдсан. Энэ хүрээнд хичээлээс гадуурх анхан, дунд, ахисан түвшний сургалтын жишиг хөтөлбөрийн дагуу анхан шатны гарын авлага боловсруулагдсан. Гарын авлага боловсруулах баг нь Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын сургуулийн багш нар, иргэдээс бүрдсэн ба БСҮХ-ээс мэргэжил, арга зүйн чиглэлээр ханган ажилласан байна. Зохиогчийн багийн гишүүд баруун, зүүн тайгын иргэдээс мэдээлэл цуглуулж, цуглуулсан мэдээлэлдээ үндэслэн эхийг бэлтгэсэн нь тус гарын авлагын онцлог болж байна.

ДЭЭД БОЛОВСРОЛЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ



БШУ-ны сайдын 2023 оны А/240 тоот тушаалаар дээд боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үзүүлэлтэд суурилан эрэмбэ, чансаа тогтоох үнэлгээний ажлын хүрээнд 4 дээд боловсролын сургалтын байгууллагад ажиллаж байна.



Эмзүйн шинжлэх ухааны их сургууль, Ач АУИС, Монгол улсын эрдмийн их сургууль, Технологийн дээд сургуулийн сургалтын хөтөлбөр, эрдэм шинжилгээнд холбогдох шалгууруудын биелэлтэд хянан баталгаажуулалт хийх ажил үргэлжилж байна.



ЭНТРЕПРЕНЕРШИПД суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийг боловсруулах багт Мэргэжлийн боловсролын 2.5 жилийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн талаар судалгааны үр дүнгээр танилцуулга хийсэн.




Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтыг өөрчлөн шинэчлэх нь Үндэсний форум II-т оролцож, “МТБС-ын багш мэргэжлийн хөгжлийн хэрэгцээ, Монгол улсын онцлог туршлага” сэдвээр илтгэл хэлэлцүүлээ

“СӨБ, ЕБС-ИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН НЭГЖ ӨРТГИЙН ТООЦООЛОЛ” СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛЖ ДУУСЛАА

“Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгж өртгийн тооцоолол” судалгааны ажлын мэдээллийг 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдөр цуглуулж дууслаа.

Тус судалгаанд хотын 7 сургууль, 5 цэцэрлэг, аймгийн төвийн 8 сургууль, 2 цэцэрлэг, сумын төвийн 6 сургууль, 2 цэцэрлэг нийт 31 сургууль, цэцэрлэг хамрагдав. Судалгаанд хамрагдсан сургууль цэцэрлэгүүдийг аймгаар зураг №1 дээр харуулбал дараах байдалтай байна.

Зураг №1. Сургууль, цэцэрлэгийн тоо



Дархан аймагт



Орхон аймагт




Сэлэнгэ аймагт



Ховд аймагт



ДОРНОД АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ҮНДСЭН АСУУДЛУУД ГАРЦ ШИЙДЭЛ СЭДЭВТ ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛД



Хүний хөгжлийн судалгааны сектор “Дорнод аймгийн нийгэм-эдийн засгийн хөгжлийн үндсэн асуудлууд-гарц шийдэл” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хуралд “Дорнод аймгийн 6-17 насны хүүхдийн хөгжлийн онцлог” сэдвээр илтгэл амжилтай хэлэлцүүлж II байр эзэлсэн нь энэ сарын онцлох ажил байлаа.




“ЕБС-ийн сурагчдын сэтгэхүйн ерөнхийлөн дүгнэх чадварын онцлог” эрдэм шинжилгээний өгүүллийг Боловсрол судлал сэтгүүлийн 6/194-д нийтлүүлээ. Өгүүлэлд бага суурь, бүрэн дунд боловсролын түвшний сурагчдын хийсвэр сэтгэхүйн хөгжлийн онцлогийг үг тодорхойлох, үгсийг нийтлэг шинжээр нь нэгтгэн дүгнэх чадваруудад тулгуурлан тайлбарлалаа.




Секторын ЭША Б.Баярмаа хүрээлэнгээс хэрэгжүүлсэн “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих нь” төслийн эцсийн тайлан, зөвлөмжийг орчуулах ажил хийж байна.

ТӨРИЙН АЛБАН ХААГЧДАД ЗОРИУЛСАН МОНГОЛ БИЧИГ СУРГАХ ГАР УТАСНЫ “ҮНДЭСНИЙ БИЧИГ” АППЛИКЕЙШНТАЙ БОЛНО



Төрийн албан хаагчдын монгол бичгийн мэдлэг чадварыг сайжруулах, сургалтыг үр дүнтэй зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх хэрэглэгдэхүүнд хөндлөнгийн хяналт, шинжилгээг хийлгэж, 20 видео хичээлийг боловсруулав.

Хяналт шинжилгээгээр: Үсэг зурлага, тулгуур ойлголт, сорил цэсийн агуулгыг “Хүмүүн бичиг” сонины эрхлэгч магистр Б.Элбэгзаяа хянан шинжилж дүгнэлт гаргаж, саналын дагуу дахин сайжруулав. Мөн техникийн саадгүй ажиллагааны хяналтыг хийж гүйцэтгэсэн байна.



Видео хичээл: Аппликейшны үзүүлэнгийн агуулгыг дэмжсэн, жишээгээр батлан тайлбарласан 5-9 минутын 20 видео хичээлийг Шинэ Монгол сургуулийн монгол бичгийн багш магистр Б.Алтанзул заалаа. Видео хичээлүүдийг аппликейшны “Хичээл” цэсэд байршуулсан бөгөөд хичээлийн танилцуулга болон бичлэгийг МУИС-ийн багш Л.Ганчимэг, ХЗХ-ийн ЭША Б.Лхагважав нар хянаж, засварлах саналуудыг оруулж сайжруулж байна.